



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/696

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч байсан Д.Батхуяг агсаны буяны ажилд буцалтгүй тусламж 100 000 төгрөг, Ахмад дайчид болон Чандмань сумын ахмад хөөмийчдэд гарын бэлэг 190 000 төгрөг, Дэлхийн зөн олон улсын байгууллагын зохицуулагч, Дээрэт олон улсын энэрлийн байгууллагын болон Мобиком корпорацийн удирдлагуудтай хийсэн уулзалтын зардалд 670 000 төгрөг, аймгийн Засаг даргын сумдад ажиллахад гарын бэлэгний зардалд 1 284 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 244 000 төгрөг /Хоёр сая хоёр зуун дөчин дөрвөн мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.3568
D/Zah-A/696-Bo